

**ТӨРИЙН ӨӨРИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТҮРЭЭСЛЭГЧИЙГ СОНГОХ
“СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ”**

1. Түрээслэгчийг сонгон шалгаруулах зарын маягт

- Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Төв эмнэлгийн гадна талбайн 2550 м.кв талбайтай нийт 80 машины хүчин чадалтай гадны талбайн авто зогсоолыг түрээслүүлнэ.
- Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Салбар эмнэлгийн гадна талбайн 560 м.кв талбайтай нийт 20 машины хүчин чадалтай гадны талбайн авто зогсоолыг түрээслүүлнэ.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа	2026 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 10 цагт /сонгон шалгаруулалтыг зараснаас хойш хуанлийн 15 хоногоос багагүй.
Материал хүлээн авах хаяг	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 31-р хороо Дилав хутагт Жамсранжавын гудамж Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 1 дүгээр давхар 135 тоот өрөө
Материал нээх хугацаа, хаяг байршил	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 31 дүгээр хороо, Дилав хутагт Жамсранжавын гудамж Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 1 дүгээр давхарт сургалтын өрөөнд 2026 оны 09 дугаар сарын 24-ны өдрийн 10 цаг 30 минут
Эд хөрөнгө түрээслүүлэх үнийн доод хэмжээ	- Төв эмнэлгийн автомашины нэг зогсоолыг сард 60,000 төгрөг (нийт 80 төлбөртэй автомашины 2550 м.кв хүчин чадалтай тоног төхөөрөмж шинээр байршуулах, гадна талбай түрээсийн доод үнийг 4,800,000 /Дөрвөн сая найман зуун мянга/ төгрөг болно) - Салбар эмнэлгийн автомашины нэг зогсоолыг 60,000 төгрөг (нийт 20 төлбөртэй автомашины 560 м.кв хүчин чадалтай тоног төхөөрөмж шинээр байршуулах, гадна талбай түрээсийн доод үнийг 1,200,000 /Нэг сая хоёр зуун мянга/ төгрөг болно)
Түрээслэгч үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийн мэдээлэл	Эрхэлдэг үйл ажиллагаа нь түрээслэх талбайн зориулалтад нийцсэн тусгай зөвшөөрөлтэй байх
Түрээслэгчийг сонгон шалгаруулах зааврын талаарх товч мэдээлэл	Эрхэлдэг үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн, туршлагатай, санхүүгийн чадвартай гэдгээ оролцогч өөрөө нотлох зорилгоор бүрдүүлэх материалыг бүрэн ирүүлнэ.
Оролцогчдын бүрдүүлж ирүүлэх материал	- Хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх - Түрээсээр эзэмших ашигтай талбай болон нийтийн эзэмшлийн талбайд явуулах үйл ажиллагааны төлөвлөгөөний танилцуулга, ажлын туршлагын талаарх мэдээлэл, (Тухайн чиглэлээр 2-с доошгүй жил үйл ажиллагаа явуулсан, ижил төстэй ажлын гэрээний хуулбар) ирүүлэх - Борлуулалтын орлогын хэмжээ: 2024, 2025 оны аль нэг жил 40 нь сая төгрөгнөөс дээш байх - Санхүүгийн чадавхыг нотлох баримт: 2024, 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, татвар, нийгмийн даатгалын цахим тодорхойлолт

	5. Ажиллах хүчний мэдээлэл, тухайн байгууллагын үндсэн ажилтан нийгмийн даатгалаар баталгаажсан байх, 6. Түрээсийн үнийн санал ирүүлэх 7. Төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн албан бичиг 8. Түрээслэх эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг хэрхэн сайжруулах тухай төсөл төсвийн тооцоололыг ирүүлэх; Сонгон шалгаруулалтад оролцох хураамж 50,000 /тавин мянга/ төгрөг
--	---

Жич:

1. Нийслэлээс гаргасан тус үйл ажиллагаатай хамаарал бүхий захирамжийг мөрдөн ажиллах
2. Эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгч эхний 120 минут үнэгүй байх
Бусад иргэд эхний 30 минут үнэгүй байх
/хэрхэн ажиллах боломжтой дижитал шийдлийг ирүүлэх/
3. Эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан иргэдийг таньж төлбөрөөс хөнгөлөх шийдэлтэй байх.
4. Ажилчдын автомашиныг бүртгэлжүүлэн үнэгүй байршуулах.
5. Хамтран ажиллах, бэлтгэн нийлүүлэх байгууллагын автомашинууд үнэ төлбөргүй нэвтэрдэг байх
6. Даваа, Лхагва, Баасан гаригуудад буяны ажлын автомашиныг үнэгүй байршуулах
7. Одоо ашиглаж буй тоног төхөөрөмжийг ашиглах бол түрээсийн үнийн санал явуулах
8. Ашиглаж буй тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хариуцдаг байх
9. Үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бусад тоног төхөөрөмжийг тухайн байгууллага өөрсдөө хариуцах
10. Төв эмнэлэг дээр бол 4 орц гарцад чиг заасан тэмдэг, тэмдэглэгээ байршуулах
11. Салбарт эмнэлэг дээр бол 1 гарцад чиг заасан тэмдэг, тэмдэглэгээ байршуулах
12. Гадна талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцаж хийх
13. Гадна талбайн аюулгүй байдлыг хариуцаж ажиллах

Сар бүрийн ашиглалтын зардлыг /түрээсийн төлбөр/-өөс тусад нь төлөх

Сонгон шалгаруулалтын материалыг зарласан хугацаанд, байгууллагын нэр, өөрийн аж ахуй нэгжийн нэр, бүрдүүлсэн материалын жагсаалт тус бүрийг дугтуйны гадна талд бичиж битүүмжилсэн хэлбэрээр ирүүлнэ үү.

Материалыг бүрэн ирүүлсэн, тавигдах шаардлагыг хангасан нэг оролцогчийг шалгаруулна.

1. Түрээслүүлэх хөрөнгийн талаар мэдээлэл авах

Түрээслүүлэх хөрөнгийг өмч эзэмшигч Гэмтэл согог судлалын үндэсний төвийн өөрийн байр дээр ирж үзэж болох ба сонгон шалгаруулалтын заавар, бүртгэх хугацаа, хөрөнгийн талаарх мэдээллийг ажлын цагаар **77115222-2** утсаар болон www.gemtel.mn цахим хуудаснаас авна уу.

**ХАЯГ: УЛААНБААТАР ХОТ, БАЯНГОЛ ДҮҮРЭГ, 31-Р ХОРОО,
ДИЛАВ ХУТАГТ ЖАМСРАНЖАВЫН ГУДАМЖ ӨӨРИЙН БАЙР.**